



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2013 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 344

Номгон

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолыг үндэслэн  
ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг идэвхтэй хэрэгжүүлэх,  
олон нийтийн оролцоог хангах, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын  
тайлангийн мэдээллийг ард иргэд, олон нийтэд мэдээлж хэвших, нээлттэй хүргэх ажлыг  
зохион байгуулах дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд зөвлөлийн дарга Д.Ганбаяр –Аймгийн Засаг даргын орлогч ✓

Гишүүд Б.Гантулга-Хөгжлийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон  
гүйцэтгэгч

Х.Бат-Оргил-Байгаль орчны газрын дарга

С.Баттулга – Галуут сумын Засаг дарга

Д.Батболд-“Хонгор нутгийн дуудлага” хөдөлгөөн ТББ-ын тэргүүн

Г.Цэрэн-“Монголын ногоонтны хөдөлгөөн”-ий салбарын зохицуулагч

Б.Наранцэцэг-Хэвлэл мэдээллийн албаны дарга

Д. Ганбаатар- “Баялаг орд” ХХК- ний захирал

Ш.Алтайсайхан- “Том шижир” ХХК-ний захирал

Д.Батхүү- “Би Эс Ай” ХХК-ний захирал

✓ Нарийн бичгийн дарга Ч. Оюунчимэг-Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

2.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын аймгийн 2013 оны  
сүүлийн хагас жилийн төлөвлөгөөг 7 дугаар сарын 1-ний дотор багтааж батлуулах,  
тайлангийн мэдээллийг ард иргэд, олон нийтэд мэдээлж, нээлттэй хүргэх ажлыг зохион  
байгуулж, ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргад танилцуулж  
ажиллахыг дэд зөвлөл /Д.Ганбаяр/-т даалгасугай.

ДАРГА



Д.ЖАРГАЛСАЙХАН

0113730